ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АСУУДЛААР ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС, МОНГОЛ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар (Америк Улс) болон Монгол Улсын Засгийн газар (Монгол Улс) (цаашид "Талууд" гэнэ):

Хоёр улсын бат бэх түншлэлийг хүлээн зөвшөөрч, эдийн засгийн нягт харилцааг бэхжүүлэхийг хүсэн;

Талуудын байгуулсан хоёр талын болон нэгдэн орсон олон талт гэрээ, тэдгээрийн дотор *Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрээр* хүлээсэн эрх, үүргийг нотлон;

Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбогдсон асуудлаар ил тод байдлыг дэмжиж, авлига, хээл хахуулиас сэргийлж, арга хэмжээ авахыг эрмэлзэн;

Дараах зүйлсийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл. Хамрах хүрээ

Энэхүү хэлэлцээр нь аль нэг Талын батлан мөрдөж буй, барааны худалдаа, эсхүл үйлчилгээний (санхүүгийн үйлчилгээнээс бусад) хил дамнасан худалдаанд нөлөөлөх, эсхүл хоёр талын хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээний худалдаа, эсхүл оюуны өмчийн эрхэд хамаарах аливаа арга хэмжээнд үйлчилнэ.

2 дугаар зүйл. Хэвлэн нийтлэх

1. Тал бүр энэхүү хэлэлцээрт хамаарах нийтээр дагаж мөрдөх хууль, дүрэм, журам, захиргааны шийдвэрийг гарсан даруйд нь хэвлэн нийтлэх буюу бусад хэлбэрээр сонирхогч этгээд болон нөгөө Талдаа танилцуулна.

2. Тал бүр боломжоороо:
   (a) батлан гаргах арга хэмжээний төслийг урьдчилан хэвлэн нийтэлнэ;
   (b) арга хэмжээний төслийн талаар санал хэлэх бодит боломжийг сонирхогч этгээд болон нөгөө Талдаа олгоно.

3. Тал бүр энэхүү хэлэлцээрт хамаарах асуудлаар төв засгийн газраас нийтээр дагаж мөрдөх бөгөөд 2(a)-д заасны дагуу хэвлэн нийтлэх эрхийн акт гаргахдаа:
   (a) эрхийн актын төслийг үндэсний албан ёсны нэг хэвлэлд хэвлэн нийтэлж, нэмэлт сувгаар түгээхийг дэмжинэ;
   (b) ихэнх тохиолдолд олон нийтийн саналыг авах хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө эрхийн актын төслийг хэвлэн нийтэлнэ;

(c) хэвлэн нийтлэхдээ эрхийн актын төслийн зорилго, үндэслэлийн тухай тайлбарыг оруулна.

4. Тал бүр энэхүү хэлэлцээрт хамаарах асуудлаар төв засгийн газраас нийтээр дагаж мөрдүүлэхээр эрхийн акт батлан гаргасан бол:
   (a) эрхийн актыг үндэсний албан ёсны нэг хэвлэлд хэвлэн нийтэлж, нэмэлт сувгаар түгээнэ;
   (b) эрхийн актын зорилго, үндэслэлийн тухай тайлбарыг албан ёсны хэвлэлдээ хэвлэн нийтлэх буюу төрийн албан ёсны цахим хуудсанд тод харагдахуйцаар байрлуулна;
   (c) санал авах хугацаанд ирүүлсэн чухал ач холбогдолтой, оновчтой саналуудад хариу өгч, эрхийн актын төсөлд оруулсан томоохон нэмэлт өөрчлөлтийн тухай тайлбарыг албан ёсны хэвлэлдээ хэвлэн нийтлэх буюу төрийн албан ёсны цахим хуудсанд тод харагдахуйцаар байрлуулна.

5. Тал бүр:
   (a) 2(a)-д заасны дагуу урьдчилан хэвлэн нийтлэхдээ арга хэмжээний төслийг англиас өөр хэлээр хэвлэн нийтлэх бол зорилго, үндэслэлийн тухай тайлбарыг нь англи хэлээр хэвлэн нийтэлнэ;
   (b) энэхүү хэлэлцээрт хамаарах арга хэмжээг англиас өөр хэлээр анх хэвлэн нийтэлвэл 90 хоногийн дотор англи хэлнээ орчуулж хэвлэн нийтэлнэ.

6. Тал бүр арга хэмжээний төслийн талаар санал өгөх боломж олгохдоо зөвхөн англи хэлээр санал өгөхийг сонирхогч этгээдэд зөвшөөрнө.

3 дугаар зүйл. Мэдээлэл өгөх

Нэг Тал нь нөгөө Талын аливаа арга хэмжээ, эсхүл арга хэмжээний төслийг энэхүү хэлэлцээрт хамаарч болно гэж үзээд мэдээлэл, тодруулга өгөхийг хүсвэл нөгөө Тал нь тухайн арга хэмжээний талаар өмнө нь мэдэгдсэн эсэхийг үл харгалзан нэн даруй гаргаж өгнө.

4 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Энэхүү хэлэлцээрийн үйлчлэлд хамаарах нийтээр дагаж мөрдөх бүх арга хэмжээг тууштай, эрх тэгш, зүй зохистой хэрэгжүүлэх үүднээс, нэг Тал нь тодорхой тохиолдолд энэ хэлэлцээрт хамаарах арга хэмжээг хэрэглэн нөгөө Талын тодорхой этгээд, бараа, үйлчилгээнд холбогдсон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа дараах нөхцлийг баталгаажуулна:
   (a) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүссэн тохиолдолд, хэрэв боломжтой бол тухайн ажиллагаанд шууд хамаарах нөгөө Талын этгээдэд тухайн Талын журмын дагуу зохих мэдэгдэл өгч, уг мэдэгдэлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, уг ажиллагааг үүсгэсэн эрх бүхий хуулийн байгууллагын мэдэгдэл,

шийдвэр болон гарсан аливаа маргаантай асуудлын тухай ерөнхий мэдээллийг тусгана;

(b) захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн шийдвэрийг гаргахаас өмнө хэрэв уг ажиллагааны мөн чанар болон нийтийн ашиг сонирхолд харшлахгүй бөгөөд цаг хугацааны хувьд боломжтой бол тухайн этгээд байр сууриа хамгаалах зорилгоор баримт нотолгоо гаргаж өгөх зохих боломжоор хангана;

(c) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрийн хуулийн дагуу явуулах.

5 дугаар зүйл. Дахин хянах, давж заалдах

1. Энэхүү хэлэлцээрийн үйлчлэлд хамаарах захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн шийдвэрийг шуурхай дахин хянах, шаардлагатай бол түүнийг залруулах зорилгоор Тал бүр шүүхийн болон шүүхийн бус, эсхүл захиргааны маргаан шийдвэрлэх байгууллага, эсхүл журмыг бий болгоно. Уг байгууллага нь захиргааны шийдвэр гаргах, хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хараат бус, бие даасан байх бөгөөд хэрэг хэрхэн шийдэгдэх тухайд бодит сонирхолгүй байна.

2. Тал бүр дээр дурдсан шүүхээр, эсхүл журмын дагуу маргааныг шийдвэрлэхдээ хэргийн оролцогч талуудыг дараах эрхээр хангана:
   (a) байр сууриа дэмжиж хамгаалах зохих боломж эдлэх;
   (b) нотлох баримт болон хэргийн материал, тухайн Талын хуулийн дагуу шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагаас бүрдүүлсэн материалыг үндэслэн маргааныг шийдвэрлүүлэх.

3. Тал бүр маргаан бүхий захиргааны хэргийн талаар гаргасан дээр дурдсан шийдвэрийг эрх бүхий байгууллага хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх явдлыг баталгаажуулах бөгөөд уг шийдвэрийг Талуудын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу давж заалдах, эсхүл дахин хянаж болно.

6 дугаар зүйл. Санхүүгийн үйлчилгээний ил тод байдал

1. Энэхүү зүйл нь санхүүгийн үйлчилгээний худалдаа болон санхүүгийн үйлчилгээний хөрөнгө оруулалттай холбогдсон Тал бүрийн арга хэмжээнд хамаарна.

2. 2 дугаар зүйлийн 2-4 дүгээр заалтад заасны дагуу Тал бүр боломжоороо:
   (a) энэхүү зүйлд хамаарах асуудлаар гаргах нийтээр дагаж мөрдөх эрхийн актын төсөл, зорилгыг урьдчилан хэвлэн нийтэлнэ;
   (b) эрхийн актын төслийн талаар санал хэлэх бодит боломжийг сонирхогч этгээд болон нөгөө Талдаа олгоно;
   (c) эрхийн актыг эцэслэн батлахдаа уг төслийн талаар сонирхогч этгээдээс ирүүлсэн чухал ач холбогдолтой, оновчтой саналд бичгээр хариу өгнө.

7 дугаар зүйл. Авлигатай тэмцэх

1. Талууд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт дахь авилга, хээл хахуулийг арилгах шийдвэр төгс байгаагаа дахин нотолж байна.

2. Тал бүр олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтад нөлөөлж буй дараах үйлдлийг өөрийн хуулиар эрүүгийн гэмт хэрэг гэж тодорхойлоход шаардлагатай хууль тогтоомж, бусад арга хэмжээг баталж мөрдөнө:
   (a) нэг Талын төрийн албан тушаалтан буюу тэр Талын нэрийн өмнөөс нийтийн үүрэг гүйцэтгэж буй этгээд албан үүргээ гүйцэтгэх үедээ хийсэн үйлдэл болон эс үйлдлийнхээ хариуд өөртөө буюу өөр этгээдэд зориулан мөнгөн дүнтэй эд зүйлс болон тусламж, амлалт, давуу байдал зэрэг бусад ашиг хонжоог шууд болон шууд бус хэлбэрээр санаатайгаар гуйх, хүлээн авах;
   (b) нэг Талын харъяа этгээд тухайн Талын албан тушаалтан буюу тухайн Талын нэрийн өмнөөс нийтийн үүрэг гүйцэтгэж буй этгээдэд албан үүргээ гүйцэтгэх үедээ хийсэн үйлдэл болон эс үйлдлийнх нь хариуд өөрт нь буюу өөр этгээдэд зориулан мөнгөн дүнтэй эд зүйлс болон тусламж, амлалт, давуу байдал зэрэг бусад ашиг хонжоог шууд болон шууд бус хэлбэрээр санаатайгаар өгөх, санал болгох;
   (c) нэг Талын харъяа этгээд олон улсын бизнес эрхлэх үедээ шинэ бизнес олох, хуучнаа хадгалах болон хууль бус бусад ашиг хонжоо олох зорилгоор гадаадын албан тушаалтанд албан үүргээ гүйцэтгэх үедээ хийсэн үйлдэл болон эс үйлдлийнх нь хариуд өөрт нь буюу өөр этгээдэд зориулан мөнгөн дүнтэй эд зүйлс болон тусламж, амлалт, давуу байдал зэрэг бусад ашиг хонжоог шууд болон шууд бус хэлбэрээр санаатайгаар өгөх, санал болгох;
   (d) нэг Талын харъяа этгээд (a)-(c) дэд заалтад заасан гэмт хэрэгт хамсан оролцох, өөгшүүлэн дэмжих, хуйвалдах.

3. Тал бүр 2 дугаар заалтын дагуу баталж мөрдөх эрүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс зохих шийтгэл, байцаан шийтгэх журмыг баталж мөрдөнө.

4. Тал бүр 2 дугаар заалтад дурдсан хээл хахуулийн үйлдлийн талаар сайн санааны үүднээс мэдээлэл өгсөн хувь хүнийг хамгаалах зохих арга хэмжээг баталж мөрдөнө.

5. Талууд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт дахь авилга, хээл хахуулийн эсрэг тэмцэхэд бүс нутгийн болон олон улсын санал санаачилга чухал болохыг хүлээн зөвшөөрнө. Талууд олон улсын хурал чуулганд холбогдох санал санаачлагыг урамшуулан дэмжих талаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ.

8 дугаар зүйл. Үл хамаарах зүйлс

1. Хууль сахиулахад саад болж, нийтийн ашиг сонирхолд харшилж, төрийн өмчлөлийн болон хувийн хэвшлийн тодорхой аж ахуйн нэгжийн хууль ёсны

арилжааны эрхийг хязгаарлаж болзошгүй нууц мэдээлэл өгөх, эсхүл уг мэдээлэлд нэвтрэх бололцоо олгохыг аль нэг Талаас шаардсан байна хэмээн энэхүү хэлэлцээрийн аль ч заалтыг ойлгож үл болно.

2. Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт дараах зүйлийг хүлээн зөвшөөрч байна гэж ойлгож үл болно:
   (a) аюулгүй байдлынх нь язгуур эрх ашигт харшлах нууц мэдээлэл өгөх, эсхүл уг мэдээлэлд нэвтрэх бололцоо олгохыг нөгөө Талаас шаардах;
   (b) олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалж, сэргээн тогтоох болон аюулгүй байдлын язгуур эрх ашгаа хамгаалах үүргээ биелүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авахад нь нөгөө Талд саад учруулах.

3. Нэг Тал нь хөрөнгө оруулагч, мөнгө хадгалуулагч, үнэт цаас эзэмшигч, санхүүгийн үйлчилгээ итгэмжлэн үзүүлж буй этгээдийг хамгаалах, санхүүгийн тогтолцооны шударга, тогтвортой ажиллагааг хангах зэрэг сэрэмжлүүлэх зорилгоор арга хэмжээ баталж мөрдөхөд энэхүү хэлэлцээрийн заалт саад болохгүй. Ийм арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн заалттай нийцээгүй бол тэдгээр арга хэмжээг тухайн заалтын дагуу тус Талын хүлээсэн үүрэг хариуцлагаас зайлсхийх арга болгон ашиглаж болохгүй.

4. Түр хугацаагаар нэвтрэх зөвшөөрөл, зөвшөөрлийн нөхцөл зэрэг цагаачлалын асуудлаар ямар нэг үүрэг аль нэг Талд хүлээлгэсэн гэж энэхүү хэлэлцээрийн аль ч заалтыг ойлгож үл болно.

5. Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт мөнгө, зээл, валютын ханшны бодлоготой холбогдсон арга хэмжээнд үл хамаарна.

6. Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт татварын арга хэмжээнд үл хамаарна. Татварын арга хэмжээнд дараах зүйл хамаарахгүй:
   (a) гадаадаас бараа оруулахтай холбогдуулан ногдуулах гааль, импортын татвар хураамж, түүнтэй холбоотой нэмэгдэл татвар хураамж;
   (b) нэг Талын хуулийн дагуу ногдуулах демпингийн эсрэг татвар;
   (c) импортын үйлчилгээ үзүүлэхэд гарсан өртгийг харьцуулан тооцож ногдуулах төлбөр хураамж.

Тийм боловч, тухайн Талын ижил төрлийн, шууд өрсөлдөх чадвартай, орлуулж болохуйц барааны хувьд, мөн импортын бараг бүхэлд нь буюу хэсэгчлэн үйлдвэрлэхэд ашигласан материалын хувьд 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ГАТТ)-ийн 3 дугаар зүйлийн 2-т нийцүүлэн ногдуулсан дотоодын татвартай тэнцэх төлбөр нь татварын арга хэмжээнд хамаарна.

9 дүгээр зүйл. Холбоо барих

Тал бүр энэхүү хэлэлцээрт хамаарах нийтээр дагаж мөрдөх арга хэмжээний талаар сонирхогч этгээд болон нөгөө Талаас тавих лавлагаа, хүсэлтэд хариу өгөх зохих механизмыг байгуулж ажиллуулна.

10 дугаар зүйл. Зөвлөлдөх

1. Нэг Тал нь энэхүү хэлэлцээрт хамаарах асуудлаар нөгөө Талтай зөвлөлдөх хүсэлт бичгээр гаргаж болох бөгөөд түүндээ хүсэлт гаргах болсон үндэслэл, хэлэлцэх арга хэмжээ, бусад асуудлыг тусгасан байна. Нөгөө Тал хүсэлтэд даруй хариу өгч, зөвлөлдөөнд сайн санааны үүднээс оролцоно. Зөвлөлдөөн энэхүү хэлэлцээрийн 2-9 дүгээр зүйлд заасан үүргээр хязгаарлагдах бөгөөд хөндөж буй арга хэмжээний агуулга, хүрээнээс халихгүй.

2. Тал бүр:
   (a) зөвлөлдөөнөөр хэлэлцэх асуудлыг бүрэн судлахын тулд хангалттай мэдээлэл гаргаж өгнө;
   (b) зөвлөлдөөнөөр солилцох нууц мэдээлэлд мэдээлэл гаргаж өгсөн Талын нэгэн адил хандана.

3. Энэхүү зүйлийн дагуу зөвлөлдөхдөө хэлэлцэх асуудлаар мэргэжсэн засгийн газрын агентлаг, бусад зохицуулах байгууллагын албан хаагчийг байлцахаар нэг Тал нь нөгөө Талаас хүсэж болно.

11 дүгээр зүйл. Тодорхойлолт

1. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор:

   албан үүргээ гүйцэтгэх үедээ хийсэн үйлдэл болон эс үйлдэл гэдэгт албан тушаалтан эрх мэдлийн хүрээнд нь багтсан эсэхийг үл харгалзан албан тушаалаа ашиглах аливаа үйлдэл хамаарна;

   нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэр гэж бүх нийтэд хамаардаг, ерөнхийдөө тодорхой хүрээнд хэрэгждэг, ёс зүйн хэм хэмжээг тогтоодог захиргааны шийдвэр, тайлбарыг хэлэх бөгөөд үүнд дараах шийдвэр хамаарахгүй:
   (a) тодорхой нөхцөлд нөгөө Талын тодорхой этгээд, бараа, үйлчилгээтэй холбогдуулан захиргааны буюу шүүхийн бус журмаар гаргасан шийдвэр;
   (b) тодорхой үйлдэл, практиктай холбогдуулан гаргасан шийдвэр;

   хөрөнгө оруулалт нь *Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай Америкийн Нэгдсэн Улс, Монгол Улсын хоорондын гэрээнд* заасан “хөрөнгө оруулалт”-тай ижил утгыг илэрхийлнэ;

төв засгийн газар гэж:

(a) Монгол Улсын хувьд Монгол Улсын Засгийн газрыг хэлнэ;

(b) АНУ-ын хувьд холбооны түвшиний Засгийн газрыг хэлнэ;

үйлчилгээний хил дамнасан худалдаа гэж дараах үйлчилгээг хэлнэ:

(a) нэг Талын нутаг дэвсгэрээс нөгөө Талын нутаг дэвсгэрт үзүүлэх үйлчилгээ;

(b) нэг Талын нутаг дэвсгэр дээр тухайн Талын этгээдээс нөгөө Талын этгээдэд үзүүлэх үйлчилгээ;

(c) нэг Талын иргэнээс нөгөө Талын нутаг дэвсгэр дээр үзүүлэх үйлчилгээ;

өдөр гэж хуанлийн өдрийг хэлнэ;

санхүүгийн үйлчилгээ нь Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн Санхүүгийн үйлчилгээний тухай хавсралтын 5(a)-д заасан тодорхойлолттой ижил байна;

гадаадын албан тушаалтан гэж гадаад улсын хууль тогтоох, захиргаа, шүүхийн байгууллагад томилогдсон буюу сонгогдсон албан тушаал хашдаг этгээдийг, мөн гадаад улсын төрийн байгууллага, төрийн өмчлөлийн аж ахуйн нэгж зэрэг төрийн аль ч түвшинд нийтийн үүрэг гүйцэтгэдэг этгээдийг, түүнчлэн олон улсын засгийн газар хоорондын байгууллагын албан хаагч, төлөөлөгчийг хэлнэ;

оюуны өмчийн эрх гэж *Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээрийн* II хэсгийн 1-7-д заасан оюуны өмчийн ангиллыг хэлнэ;

арга хэмжээ гэж хууль, дүрэм, журам, шийдвэр, практик ажиллагааг ойлгоно;

нөгөө Талын хувь хүн гэж:

(a) Монгол Улсын хувьд Харъяатын тухай хуульд тодорхойлсон "Монгол Улсын иргэн"-ийг хэлнэ;

(b) АНУ-ын хувьд Цагаачлал, иргэний харъяаллын тухай хуульд заасан "АНУ-ын иргэн"-ийг хэлнэ;

этгээд гэж хувь хүн, хуулийн этгээдийг хэлэх бөгөөд энэхүү хэлэлцээрийн (b)-д зааснаас хамаарч *Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн* XXVIII зүйлийн (l)-д заасантай ижил утгатай байна;

нөгөө Талын этгээд гэж нөгөө Талын хувь хүн, хуулийн этгээдийг хэлэх бөгөөд энэхүү зүйлийн (b)-д зааснаас хамаарч *Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн* XXVIII зүйлийн (m), (n)-д заасан **"бусад гишүүний хуулийн этгээд"** гэсэн тодорхойлолттой ижил утгатай байна;

худалдан авах ажиллагаа гэж засгийн газар бараа, үйлчилгээг арилжаа, үйлдвэрлэлийн зорилгоор борлуулах, нийлүүлэх зорилгогүйгээр зөвхөн өөрийн хэрэгцээнд худалдан авах, ашиглах болон тэдгээрийн хосолсон үйлдлийг хэлнэ;

нийтийн үүрэг гэж нэг Талын нэрийн өмнөөс тэр Талын төв засгийн газрын түвшинд худалдан авах ажиллагаа зэрэг үйлчилгээ үзүүлэх зорилгоор хувь хүний түр буюу байнга, төлбөртэй буюу төлбөргүйгээр гүйцэтгэх үүргийг хэлнэ;

төрийн өмчлөлийн аж ахуйн нэгж гэж:

(a) засгийн газар нийт хувьцааных нь 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа аж ахуйн нэгж, эсхүл

(b) засгийн газар удирдлагынх нь олонхийг томилох, үйл ажиллагааг нь хуулийн чиглүүлэх эрхтэй аж ахуйн нэгжийг

хэлэх бөгөөд аливаа нэгтгэл, траст, нөхөрлөл, дан төрийн өмчлөлийн нэгж, хамтарсан компани, нийгэмлэг буюу эдгээртэй ижил төстэй байгууллага үүнд хамаарна;

төрийн албан тушаалтан гэж нэг Талын төв засгийн газар томилогдон буюу сонгогдон ажиллаж байгаа албан тушаалтан, албан хаагчийг хэлнэ;

хэвлэл нийтлэх гэдэгт өөрөөр заагаагүй бол олон нийтэд нээлттэй засгийн газрын цахим хуудсанд баримт бичгийг байрлуулах мөн хамаарна.

2. Энэхүү зүйлийн зорилгоор *Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн* XXVIII зүйлийн (l), (m), (n) заалтыг энэхүү хэлэлцээрт багтаан салшгүй хэсэг болгосон бөгөөд “Гишүүн”-ийг “Тал” болгож, “бусад гишүүн“ гэснийг хасав.

12 дугаар зүйл. Төгсгөлийн заалт

1. Талуудын байгуулсан хоёр талын болон нэгдэн орсон олон талт гэрээ, түүний дотор *Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийн* дагуу харилцан хүлээсэн эрх, үүргээ Талууд нотолж байна.

2. Бараа, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, этгээдэд энэхүү хэлэлцээрээр олгосноос илүү тааламжтай нөхцөл олгож буй Талуудын олон улсын эрх зүйн үүргээс татгалзах ёстой гэж энэхүү хэлэлцээрийг ойлгож болохгүй.

3. Энэхүү хэлэлцээрийг тайлбарлахдаа олон улсын нийтлэг эрх зүйн тайлбар хийх зан заншлын хэм хэмжээг баримтална.

4. Талууд бичгээр тохиролцож энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Талууд нэмэлт, өөрчлөлтийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн тухайгаа бичгээр харилцан мэдэгдсэний дараа Талуудын тохиролцсон өдрөөс эхлэн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

5. Талууд энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн тухайгаа бичгээр харилцан мэдэгдсэнээс хойш 60 хоногийн дараа, эсхүл Талуудын тохиролцсон өдрөөс энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

6. Нэг Тал нь энэхүү хэлэлцээрийг цуцлах тухайгаа нөгөө Талдаа бичгээр мэдэгдсэнээс хойш 180 хоногийн дараа энэхүү хэлэлцээр цуцлагдана.

Энэхүү хэлэлцээрийг Нью Йорк хотноо 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр монгол, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН	МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ	ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ